

20 Unwider (heute)

УРЛАН

“Улаанбаатар”-ын өөр өнгө

ХБНГУ-ын Берлин хотын уран бүтээлч, хүүхдийн номын зураач Патрициа Тома “Norphei” арт галерейд “Улаанбаатар” нэртэй үзэсгэлэн дэлгэв. Тэрбээр ер бусын өнгө төрх, өргөн уудам хэв шинжийг эрэлхийлэн Улаанбаатар хотыг зорин иржээ. Бүтээлүүддээ манай хотын өндөг булан бүрийг нарийвчлан дүрслэхийг хичээсэн аж. ХБНГУ-ын Бонн хотын урлагийн музейн куратор Сабина Лесманн тус үзэсгэлэнгийн талаар “Уран бүтээлчийн нүдээр ажигхуйд тал нутаг болон хотын зохицол яг л дэлгэсэн зураг мэт өргөн уудам руу алсарсаар, бүхнийг өөртөө уусган нэгтгэх шиг. Улаанбаатар хотод нарийн бөгөөд урт урт гудамжууд, аж үйлдвэрийн бүсүүд сунайна. Энэ мэт зураглал дахин дахин давтагдах аж. Учир нь Улаанбаатар хотын орчин тойрон гарт баригдам ойрхон хэрнээ улам бүр л алсран холдсоор байна. Нимгэхэн цаасан дээр буун, бүдгэрсэн будгийн ул мөр Улаанбаатар хотын дээгүүр татсан сиймхий гивлүүр мэт сэтгэлийг анирдан тайвшруулна” гэжээ. График, холимог техникийн аргаар бүтээсэн есөн сонирхолтой бүтээлийг энэ сарын 22 хүртэл үзэх боломжтой.

